ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

# ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН ТУШААЛААР ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

/2018 оны I улирлын байдлаар/ 2018.04.10

Зам, тээврийн хөгжлийн сайдын 160 тушаалын 295 заалтыг хяналтад авч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Сайдын тушаалын хэрэгжилтийн байдалд 2018 оны I улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд бүрэн хэрэгжсэн 47, 70%-ийн хэрэгжилттэй 131, 30%-ийн хэрэгжилттэй 44, хэрэгжүүлэх хугацаа болоогүй 36, хүчингүй болсон 20 заалт, 17 заалт хэрэгжээгүй болон биелэлтээ ирүүлээгүй, хэрэгжилтийн хувь **63,6** байна.

ЗТХС-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хариуцан хэрэгжүүлэх байгууллага, газар тус бүрээр нь гаргавал дараах байдалтай байна. Үүнд:

| № | Газрын нэрс | Нийт заалт | Үүнээс /хувиар/ | | | | | | Биелэлт /хувь/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 70 | 30 | Хэрэгжээгүй, биелэлт ирүүлээгүй | Хугацаа болоо-гүй | Хүчин-гүй болсон | |
| 1 | **Дэд сайд** | 18 | 3 | 13 | 2 | - | - | - | **70.6** |
| 2 | **ТНБД** | 38 | 4 | 21 | 7 | - | 4 | 2 | **65.0** |
| 3 | **БТГ** | 57 | 9 | 22 | 14 | 2 | 4 | 6 | **60.8** |
| 4 | **ТЗУГ** | 35 | 10 | 14 | 4 | - | 3 | 4 | **75.0** |
| 5 | **ХШҮДАГ** | 60 | 8 | 32 | 4 | 1 | 10 | 5 | **70.2** |
| 6 | **АЗБХЗГ** | 46 | 5 | 23 | 9 | - | 8 | 1 | **64.3** |
| 7 | **АТБХЗГ** | 28 | 10 | 13 | 2 | 1 | - | 2 | **75.8** |
| 8 | **ТЗДТБХЗГ** | 37 | 7 | 16 | 5 | - | 3 | 6 | **70.4** |
| 9 | **АТБХЗХ** | 28 | 9 | 14 | 2 | - | 1 | 2 | **77.6** |
| 10 | **ИНЕГ** | 52 | 12 | 14 | 8 | 8 | 10 | - | **57.6** |
| 11 | **ЗТХТ** | 32 | 8 | 13 | 4 | 5 | 2 | - | **61.0** |
| 12 | **АТҮТ** | 47 | 18 | 14 | 6 | 5 | 2 | 2 | **68.8** |
| 13 | **ГТХЗНТ** | 27 | 7 | 9 | - | 2 | 8 | 1 | **73.9** |
| 14 | **МИАТ** | 20 | 1 | 3 | - | 15 | 1 | - | **16.3** |
| 15 | **УБТЗ** | 33 | 3 | 7 | 3 | 17 | 3 | - | **29.3** |
| 16 | **МТЗ** | 25 | 14 | 5 | - | 1 | 5 | - | **87.5** |
| 17 | **Далайн захиргаа** | 32 | 6 | 4 | 3 | 14 | 2 | 3 | **35.9** |
| 18 | **НТОЗШША** | 15 | 6 | 2 | 3 | 4 | - | - | **55.3** |
| 19 | **Төслийн нэгжүүд** | 7 | - | 5 | - | - | 2 | - | **70.0** |
| 20 | **Уурхай эзэмшигч компаниуд** | 12 | - | 2 | 4 | 5 | - | 1 | **23.6** |
| 21 | **Монголын автотээвэрч-дийн нэгдсэн холбоо** | 1 | - | 1 | - | - | - | - | **70.0** |
| 22 | **БТЕГ** | 2 | - | - | - | 1 | 1 | - | **0,0** |
| | **Нийт** | **295** | **47** | **131** | **45** | **16** | **36** | **20** | **63,7** |

Сайдын 2013 оны 2, 2014 оны 2, 2015 оны 25, 2016 оны 41, 2017 оны 67, 2018 оны 23, нийт 160 тушаал хяналтад байгаагаас 18 нь байнгын хяналтад байх дүрэм, журам, загвар, зөвлөмж, норм баталсан тушаал, 11 нь дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөгөө баталсан, 19 нь байнгын ажиллагаатай хороо, ажлын хэсэг, комисс томилсон тушаал, 39 нь нэг удаагийн үүрэг даалгавар хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулсан тушаал байна.

Хяналтад байгаа 48 ажлын хэсэгт өгсөн 53 үүрэг даалгаврын 12 нь хэрэгжсэн буюу хэрэгжилт тогтмолжсон, 27 нь 70%-ийн хэрэгжилттэй, 13 нь 30%-ийн хэрэгжилттэй, 1 нь хэрэгжээгүй, хэрэгжилтийн хувь 66,9 байна.

Байнгын үйл ажиллагаатай 17 ажлын хэсгээс 5 нь 2018 онд хуралдсан, үйл ажиллагаа нь жигдэрсэн байна. Үлдсэн 12 ажлын хэсэг, зөвлөл, хороо нь 2018 онд хуралдаж төлөвлөгөөгөө гаргаагүй, 2017 оны ажлаа дүгнээгүй, зарим нь байгуулагдсанаасаа хойш хуралдаагүй байна. Тухайлбал: Дотоод аудитын хороо, Зам, тээврийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөл, Иргэний нисэхийн эрэн хайх, авран туслах үйл ажиллагааны бэлтгэл, төлөвлөлтийг зохицуулах хороо, Салбарын норматив баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох сангийн Хяналтын зөвлөл нь 2016, 2017 онд хуралдаагүй байна. Мөн Шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх хороо болон Төслийн удирдах хороонуудыг зам, барилгын улирал эхлэхээс өмнө хуралдуулж, төслийн ажлыг графикийн дагуу хэрэгжүүлэхэд шаардлагатай асуудлуудыг шийдвэрлэх нь зүйтэй байна.

Хяналтад байгаа 295 заалтын 61 нь байнгын болон урт хугацааны үүрэг даалгавар өгсөн, 47 нь үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх хугацаа заасан, 187 заалт буюу 63,4% нь хэрэгжүүлэх хугацаа заагаагүй үүрэг даалгавар байна.

МИАТ ХК, УБТЗ ХНН-ээс бусад харьяа байгууллага, газар, хэлтсүүд 2018 оны I улирлын тайлангаа ирүүлсэн боловч ХШҮДАГ, АТБХЗГ, ГТХЗНТ, МТЗ ТӨХК, НТОЗШША-аас бусад харьяа байгууллагууд болон газар, хэлтсүүд хугацаа хоцроож ирүүлсэн.

2013-2016 оны тушаалуудын 315 заалтыг яаралтай хэрэгжүүлэх талаар хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласны дүнд жилийн эцсийн байдлаар 245 нь хэрэгжсэн, хэрэгжилт тогтмолжсон болон хүчингүй болсон тул хяналтаас хасагдсан байна. Үлдсэн 70 заалтыг ойрын хугацаанд хэрэгжүүлж, биелэлтийг тайлагнан хяналтаас хасуулах шаардлагатай байна. Хэрэгжилт удаашралтай байгаа заалтуудыг хавсаргав. /Хавсралт 1/

Хүчингүй болсон тушаалыг дахин хүчингүй болгосон, өмнөх тушаалыг хүчингүй болголгүй дахин ижил агуулгатай тушаал гаргасан, өөр агуулгатай тушаалыг андуурч хүчингүй болгосон зэрэг дутагдал гарч байгаа тул Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаал, шийдвэрийн бүртгэл, кодификаци хийх ажлыг сайжруулах, бүртгэл мэдээллийн системийг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Авто замын чиглэл тогтоох тухай 14, агаарын тээвэрлэгчийг томилох тухай 8, тээвэрлэлтийн чиглэл тогтоох тухай 7 тушаал хяналтад байгаа бөгөөд авто замын чиглэл тогтоох хүсэлт тавьсан уурхай эзэмшигч компаниуд авто зам барих хөрөнгөгүй гэсэн шалтгаанаар авто зам барилгын ажлаа эхлэхгүй, тухайн чиглэлд тээвэр гүйцэтгэх компани нь хүсэлтээ ирүүлэхгүй, агаарын тээвэрлэгчээр томилогдсон компаниуд нислэг үйлдэхгүй байгаагаас тушаалууд хэрэгжихгүй удаашралтай байна.

Ажлын хэсгийн ахлагч, нарийн бичгийн дарга, гишүүд ажлаас чөлөөлөгдсөнөөс тухайн ажлын хэсгийн ажил удааширч хугацаа алдах тохиолдол гарч байгаа тул асуудал хариуцсан мэргэжилтэн чөлөөлөгдсөн тохиолдолд тухай бүр тушаалд нэмэлт өөрчлөлт оруулж байх,

байнгын ажиллагаатай ажлын хэсгийн ахлагч, нарийн бичгийн дарга, гишүүдийг албан тушаалын нэрээр томилж байх нь зүйтэй байна.

Мөн тухайн асуудлыг хариуцсан газар, хэлтсүүд нь байхад тодорхой нэг асуудлаар санал боловсруулах, дүгнэлт гаргах, судалж танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгүүд байгуулж байгаагаас олон газар, хэлтсийн дунд ажил цалгардах, хугацаа алдах, хариуцлагаас зайлсхийх зэрэг муу нөлөөтэй байна.

Тушаалын биелэлтийг тайлагнах үед харьяа байгууллага, яамны газар, хэлтсийн мэргэжилтнүүд өөрт холбоотой тушаал шийдвэр гарсныг мэдээгүй гэх гомдол гарсан хэвээр байна.

**Санал, зөвлөмж:**

1. Газар, хэлтэс, харьяа байгууллагууд хэрэгжүүлэх хугацаа хэтэрсэн болон удаашралтай хэрэгжиж байгаа (ялангуяа 2013-2017 оны) үүрэг даалгаврыг 2018 оны I улиралд багтаан хэрэгжүүлж дуусгах, шаардлагагүй бол хүчингүй болгох;

2. Сайд, ТНБД-ын тушаалын бүртгэл, мэдээллийн системийг боловсронгуй болгох;

3. Ажлын хэсгийн ахлагч, нарийн бичгийн дарга, гишүүд ажлаас чөлөөлөгдсөн тухай бүр тушаалд нэмэлт өөрчлөлт оруулж байх, байнгын ажиллагаатай ажлын хэсгийн ахлагч, нарийн бичгийн дарга, гишүүдийг албан тушаалын нэрээр томилж байх, зайлшгүй шаардлагатай тохиолдолд ажлын хэсэг байгуулж байх;

4. Байнгын ажиллагаатай салбар зөвлөл, комисс, ажлын хэсгүүдийг оны эхэнд багтаан хуралдуулж, төлөвлөгөөг батлан байнгын ажиллагааг ханган ажиллах, жилийн эцэст төлөвлөгөөт ажлаа дүгнэж хэвших;

5. Тээвэрлэлтийн чиглэл, авто замын чиглэл тогтоосон, агаарын тээвэрлэгчийг томилсон тушаал ямар хугацаанд хүчинтэй байх талаар Хуулийн хэлтэс дүгнэлт гаргаж цаашид тушаалыг хугацаатай болгож цэгцлэх;

6. Тушаал боловсруулан гаргасан ажилтан "Зам, тээврийн хөгжлийн яамны албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны журам"-ын дагуу тухайн тушаалаар үүрэг өгөгдсөн байгууллага, албан тушаалтанд тушаалын хувийг албан ёсоор хүргүүлж хэвших, ТЗУГ-аас хяналт тавьж ажиллах;

7. Тушаалд тухайн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх хугацааг заавал тусгаж байх;

Танилцсан:

| | |
|---|---|
| Сайд | Ж.Бат-Эрдэнэ |
| Төрийн нарийн бичгийн дарга | Ж.Бат-Эрдэнэ |
| Төрийн захиргааны удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч | Б.Махбал |
| Бодлого төлөвлөлтийн газрын дарга | Р.Мэргэн |

| | |
|---|---|
| Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга | Д.Доржханд |
| Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга | С.Батболд |
| Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга | Б.Артур |
| Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга | С.Мөнхнасан |

Хянасан:

| | |
|---|---|
| ХШҮДАГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч | Т.Гомбосүрэн |

Боловсруулсан:

| | |
|---|---|
| ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн | Д.Баярмаа |

Хавсралт

## Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгавраас хэрэгжилт удаашралтай байгаа заалтууд

| № | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Хэрэгжүүлэх заалт | Хэрэгжүүлэх газар, хэлтэс, хугацаа | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1. | Авто замын чиглэл батлах тухай 2013.05.06 №106 | 2.Батлагдсан чиглэлийн дагуу авто замын инженерийн нарийвчилсан зураг төслийг боловсруулж, барих, ашиглах талаар гэрээ байгуулан хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг ТНБД Б.Батзаяад, шаардлага хангасан авто зам барьсны дараагаар тээвэрлэлтийг эхлүүлэхийг “Терра Энержи” ХХК-д, батлагдсан чиглэлийг мэдээллийг санд бүртгэж, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг АЗБХЗГ /Р.Онон/-т тус тус үүрэг болгосугай. /Өмнөговь Ноён сум Баруун Ноён уулын нүүрсний уурхайгаас Нарийн сухайт – Шивээхүрэн чиглэлийн авто замтай нийлэх 98,4 км авто замын чиглэл/ | ТНБД АЗБХЗГ “Терра Энержи” ХХК | 2013.10.04-ны өдөр Терра энержи ХХК-ийн ирүүлсэн хүсэлт болон хурлын тэмдэглэлийг үндэслэн ЗТЯ-ны ЗТХБГ-аас ажил эхлүүлэх зөвшөөрлийг олгосноор зам барилгын ажлаа эхлүүлсэн бөгөөд одоогоор зөвхөн хөрс хуулалт, ухмал, далангийн ажил хийгдээд байна. Ажлын явц 9 хувь. 2016.12.28-ны өдөр 96 дугаартай нэмэлт гэрээ байгуулсан. Уг гэрээгээр зам барилгын ажлын гүйцэтгэх хугацааг 2019.06.17-ны өдөр хүртэл сунгасан. Зам барилгын ажил хөрөнгө санхүүжилтгүйн улмаас зогссон.<br>Одоогийн байдлаар зам барилгын ажил үргэлжлүүлэх хүсэлт ирүүлээгүй байна. | 30 |
| 2. | Авто замын чиглэл батлах тухай 2015.01.16 №16 | 2.Батлагдсан чиглэлийн дагуу авто замыг барих, ашиглах талаар гэрээ байгуулах, батлагдсан чиглэлийг мэдээллийн санд бүртгэж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг АЗТБХЗГ /Ц.Цогтбаатар/-т үүрэг болгосугай. /Улаан-Овоогийн нүүрсний уурхайгаас Зэлтэрийн боомт хүртэл 18.5км/ | АЗБХЗГ | Тушаалыг хүсэлт гаргасан уурхай эзэмшигч компанид хүргүүлсэн. Батлагдсан чиглэлийг мэдээллийн санд бүртгэж авсан. Санхүүгийн хүндрэлтэй асуудлаас шалтгаалан авто замын барилгын ажлыг эхлүүлэх боломжгүй байгаа талаар тус компаниас мэдэгдсэн. Зам барилгын ажил эхлүүлээгүй. Тухайн чиглэлийг батлахад олон төрлийн судалгаа, зөвшөөрөл авдаг учир нэгэнт батлагдсан чиглэлийг хадгалах нь зүйтэй юм. | 30 |
| | | 3.Авто замын инженерийн нарийвчилсан зураг төслийг боловсруулж, зургийн дагуу шаардлага хангасан авто зам барьсны дараагаар тээвэрлэлтийг эхлүүлэхийг уурхай эзэмшигч компанид даалгасугай. | уурхай эзэмшигч компани | Санхүүгийн хүндрэлтэй асуудлаас шалтгаалан авто замын барилгын ажлыг эхлүүлэх боломжгүй байгаа талаар тус компаниас мэдэгдсэн. ОХУ-д долларын ханш өссөнөөс шалтгаалан нүүрс экспортлох гэрээ ашиггүй болсон тул авто зам барих ажил хойшлогдсон | 0 |
| 3. | Зам хариуцагчийн | 2. Дараах арга хэмжээ авч ажиллахыг АЗТБХЗГ /Ц.Цогтбаатар/, СЭЗХ /З.Цэрэнчимэг/-т тус тус | АЗБХЗГ | Улсын комиссын актанд шинээр ашиглалтад орж байгаа зам, гүүрийн ашиглагч байгууллагыг зааж өгдөг. | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | замын урт, бүртгэл мэдээллийн санд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2015.03.11 №57 | даалгасугай. 2.1. "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан орон нутгийн чанартай гүүрүүд" /3 дугаар хавсралт/-ийг холбогдох орон нутагт нь шилжүүлэх, данс бүртгэлд нь тусгуулах | | Тушаалын хавсралт 3-т заасан Архангай аймгийн Батцэнгэл сумын Хойд Тамирын голын 210.64 у/м төмөрбетон гүүрийг Архангай аймгийн ЗДТГ-т, Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Хүдэрийн голын 72.85 у/м төмөрбетон гүүрийг Сэлэнгэ аймгийн ЗДТГ-т, Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Могойтын голын 108.95 у/м төмөрбетон гүүрийг Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын ЗДТГ-т хариуцуулсан. Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Үүрийн голын 350 у/м төмөрбетон гүүрийн барилгын ажлын явц 100%-тай байна. Гүүрэнд илэрсэн гажилтын улмаас гүүрийг ашиглалтад оруулах улсын комисс ажиллаагүй, ашиглалтанд хүлээж аваагүй байна. Гүүрэнд гарсан хэв гажилтын талаар дүгнэлт гаргах ажлын хэсэг "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ дээр байгуулагдаж, газар дээр нь ажилласан бөгөөд гүүрийг засах аргачлал, цаашид ашиглахтай холбоотой асуудлыг Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэх санал дүгнэлтийг ирүүлсэн. Зохиогчийн хяналтын дүгнэлт гарсан. Хөндлөнгийн шинжээчийн баг томилж, газар дээр нь ажиллуулахаар шийдвэрлэсэн. Цагаан-Үүрийн гүүрийг Статик, динамик ачаалалд оруулан барилгын ажлын чанар байдалд дүгнэлт гаргах ажлыг ШУТИС-ын Оношлогоо, зураг төсөл, судалгааны төвөөс газар дээр нь хэмжилт хийсэн, дүгнэлтийг гаргаж ирүүлсэн бөгөөд ХШҮДАГ-т өгсөн. Гүүрийг ашиглах боломжтой эсэх, улсын ашиглалтад оруулах асуудлыг холбогдох газар нь шийдвэрлэх болно. | |
| 4. | Хурдны замын трасс батлах тухай 2015.04.02 №90 | 2.Батлагдсан чиглэлийг мэдээллийн санд бүртгэж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг СБТХАГ /С.Адъяасүрэн/-т даалгасугай. /"Алтанбулаг-УБ-Замын-Үүд чиглэлийн хурдны авто замын төсөл"-ийн замын чиглэл, урт/ | БТГ | Батлагдсан чиглэлийг мэдээллийн санд бүртгэж авсан. Хурдны авто замын инженерийн нарийвчилсан хайгуул, зураг төсөл боловсруулах ажлын даалгавар боловсруулж дууссан ба Засгийн газрын 2015.04.20-ний өдрийн хуралдаанаар Чингис ланд девелопмент ХХК-ийн хурдын авто замын асуудлыг хэлэлцсэнтэй холбоотойгоор тухайн замтай холбогдох аливаа ажлыг түр зогсоогоод байгаа тул даалгавар албажаагүй байна. "Чингис ланд девелопмент" ХХК-наас 2016 оны 08 | 30 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | дугаар сарын 10-ны өдрийн 16/13 тоот албан бичгээр гэрээ байгуулах талаар хариу ирүүлсний дагуу ЗТХЯ-ны АЗБХЗГ-ын даргын 2016 оны 08 дугаар сарын 30-ний өдрийн 06/399 тоот албан бичгээр "Концессын гэрээгээр ТХХТ-ийн хүрээнд гүйцэтгүүлэх концессын зүйлийн жагсаалтад тусгагдсан тухайн чиглэлийн авто замын барилгын ажлыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг чиг үүргийн дагуу ҮХГ хариуцаж байгаа бөгөөд ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээнд уг төслийг хэрэгжүүлэх, хяналт тавих эрх шилжүүлэн ирээгүй тул ҮХГ-т асуудлыг тавьж шийдвэрлүүлэх талаар хариу хүргүүлсэн. | |
| | | 4. Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт Хоолтын даваа Маань сумын чиглэлийн трассын 347.2 км-444.4 км-ийг ЗГХЭГ-ын даргын 2015 оны 25 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг дээр Богдхан төмөр замын трасстай уялдуулан яаралтай шийдүүлэхийг АЗТБХЗГ /Ц.Цогтбаатар/-т даалгасугай. | АЗБХЗГ | Тус ажлын хэсгээс шийдвэр гараагүй, 2017 онд Богд хаан төмөр замын трассын судалгааны ажил хийгдсэн. Цаашид санхүүжилтийн асуудал шийдэгдсэн тохиолдолд ТЭЗҮ, зураг төслийн ажил үргэлжлэн хийгдэнэ гэсэн мэдээллийг ТЗДТБЗГ-аас өгсөн. Засгийн газрын 2015 оны 158 дугаар тогтоолоор "Чингис девелопмент" ХХК-тай байгуулсан “Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хурдны авто замын төсөл”-ийн концессын гэрээг цуцалсан. Гэрээ цуцалсантай холбогдуулан тус хурдны авто замын төсөлтэй холбоотой үйл ажиллагаа явуулахгүй байх чиг үүрэг өгөгдсөн. Концесс эзэмшигч гэрээ цуцалсан асуудлаар шат шатны шүүхэд хандан хэлэлцэгдсээр 2016 онд Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны Иргэний хэргийн шүүхээс Засгийн газрын 2015 оны 158 дугаар тогтоолыг хүчингүй болгох тухай тогтоол гарсан.<br>Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 40 дүгээр тэмдэглэлээр шүүхийн шийдвэрийг биелүүлэх талаар тодорхой санал боловсруулж Засгийн газарт танилцуулахыг Үндэсний хөгжлийн газрын дарга болон Зам,тээврийн хөгжлийн сайдад даалгасан. Үүний дагуу Үндэсний хөгжлийн газраас хамтарсан ажлын хэсэг байгуулан, тодорхой санал, дүгнэлт боловсруулж, Засгийн газрын Хэрэг | 30 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | эрхлэх газарт хүргүүлсэн. Тус хурдны замын концессын гэрээг үргэлжлүүлэх эсэх шийдвэр гараагүй тохиолдолд замын трасс батлах асуудлыг шийдвэрлэх боломжгүй. | |
| 5. | Авто замын чиглэл батлах тухай 2015.04.16 №105 | 3.Авто замын инженерийн нарийвчилсан зураг төслийг боловсруулж, зургийн дагуу шаардлага хангасан авто зам барьсны дараагаар тээвэрлэлтийг эхлүүлэхийг "Засагчандмань майнз" ХХК-ийн Ерөнхийлөгч бөгөөд Ерөнхий захирал /Д.Буянтогтох/-д даалгасугай. | уурхай эзэмшигч компаниуд | Чиглэл баталсан сайдын тушаалыг "Засагчандмань майнз" ХХК-д хүргүүлсэн. Засгийн газрын 2017 оны 28 дугаар тогтоолоор чиглэл өөрчлөгдөн концессын зүйлийн жагсаалтад оруулсантай холбогдуулан концессын гэрээ байгуулж, зураг төсөл боловсруулах зөвлөх компаниар "Мөнхийн тод зам" ХХК-ийг сонгон гэрээ байгуулж, ажлыг нь эхлүүлсэн. | 30 |
| 6. | Хөтөлбөр батлах тухай 2015.06.24 №177 | 2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дэд хөтөлбөр, ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж ажиллахыг АЗТБХЗГ /Д.Доржханд/, ТЗДТБХЗГ /Ч.Цогтбаяр/, АТБХЗХ /С.Мөнхнасан/-т даалгасугай. /Зам, тээврийн салбарт инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр/ | АЗБХЗГ<br>АТБХЗГ<br>АТБХЗХ | Автотээврийн салбарын инновацийн дэд хөтөлбөрийн төслийг боловсруулан Нийслэлийн тээврийн газар, Механик инженерийн сургууль, Тээврийн дээд сургууль, "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ зэрэг газруудад хүргүүлж, ирүүлсэн саналуудыг нэгтгэн боловсруулж БТГ-т хүргүүлсэн.<br>"Авто замын салбарын эрдэм шинжилгээ инновацийг хөгжүүлэх хөтөлбөр" боловсруулж, холбогдох газруудын саналыг тусган эцэслэн боловсруулж, авто замын салбарын болон яамны ШУТЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн дэмжүүлээд байна.<br>"Төмөр замын тээврийн салбарын эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийг хөгжүүлэх дэд хөтөлбөр"-ийг боловсруулан ЗТХ-ийн сайдын 2016 оны 61 дүгээр тушаалаар батлуулсан.<br>"Иргэний нисэхийн салбарт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, ажлын төлөвлөгөө"-г шинэчлэн боловсруулж, ИНЕГ-ын 2017 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 01/2463 тоот албан бичгээр ирүүлсэн бөгөөд төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг 2018 оноос хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. | 70 |
| 7. | Авто замын чиглэл батлах тухай 2015.10.13 №267 | 2.Батлагдсан чиглэлийн дагуу авто замыг барих, ашиглах талаар гэрээ байгуулах, батлагдсан чиглэлийг мэдээллийн санд бүртгэж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг АЗТБХЗГ /Д.Доржханд/-т үүрэг болгосугай. /Цахиурт- | АЗБХЗГ | Чиглэл баталдсан тушаалыг уурхай эзэмшигчид хүргүүлсэн. Батлагдсан чиглэлийг мэдээллийн санд бүртгэж авсан. Одоогоор тус компаниас авто зам барих талаар гэрээ байгуулах хүсэлт ирүүлээгүй бөгөөд зам барилгын ажил эхлээгүй. | 30 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Овоогийн төмрийн хүдрийн уурхайгаас Баруун-Урт-Бичигтийн боомт чиглэлийн авто замтай холбогдох 46.6 км авто зам/ | | | |
| | | 3.Авто замын инженерийн нарийвчилсан зураг төслийг боловсруулж, зургийн дагуу шаардлага хангасан авто зам барьсны дараагаар тээвэрлэлтийг эхлүүлэхийг уурхай эзэмшигч компанид даалгасугай. | уурхай эзэмшигч компаниуд | Чиглэл баталсан сайдын тушаалыг "Засагчандмань майнз" ХХК-д хүргүүлсэн. Шаардлага хангасан авто зам барьсны дараа тээвэрлэлт эхлүүлэх боломжтойг мэдэгдсэн. Тус компаниас одоогоор тухайн авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын даалгавар авах хүсэлт ирүүлээгүй байна. | 0 |
| 8. | Авто замын чиглэл батлах тухай 2015.11.16 №307 | 3.Авто замын инженерийн нарийвчилсан зураг төслийг Чойбалсан-Баянхошуу чиглэлийн авто замын зураг төсөлтэй уялдуулан боловсруулж, зургийн дагуу шаардлага хангасан авто зам ашиглалтад оруулсны дараа тээвэрлэлтийг эхлүүлэхийг уурхай эзэмшигч "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-д даалгасугай. | уурхай эзэмшигч компаниуд | Тус чиглэлийн авто замын зураг төсөл боловсруулах ажлын гэрээг 2017.11.13-ны өдөр "Ай Си Ти сайн консалтинг" ХХК-тай байгуулж, зураг төсөл боловсруулах ажлыг эхлүүлсэн. | 30 |
| 9. | Авто замын чиглэл батлах тухай 2015.11.25 №316<br><br>/2015.12.18-ны №355 тушаалаар 3 дахь заалтыг хүчингүйд тооцсон/ | 2.Замын трассын дайран өнгөрөх цэгүүдийг зураг төсөл боловсруулах шатанд нарийвчлан тогтоолгож, батлагдсан чиглэлийн дагуу авто замыг барих, ашиглах, шилжүүлэх гэрээ байгуулах, батлагдсан чиглэлийг мэдээллийн санд бүртгэж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг АЗТБХЗГ /Д.Доржханд/-т үүрэг болгосугай. /Хөөтийн нүүрсний уурхайгаас Бичигт боомт хүртэлх авто замын чиглэл/ | АЗБХЗГ | Чиглэл баталсан тушаалыг "Буман-Олз" ХХК-д хүргүүлсэн. Батлагдсан чиглэлийг мэдээллийн санд бүртгэж авсан.<br>Тус компаниас замын зураг төслийг мэргэжлийн компаниар гүйцэтгүүлсэн ба зам барилгын ажлыг гүйцэтгэгч компанийг сонгосон тул ажил эхлүүлэх зөвшөөрөл олгохыг хүссэн албан бичиг ирүүлсний дагуу Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосон. 2017 онд 20 км-т хөрс хуулалт, 10 км-т далангийн 1-р үеийн дүүргэлт хийгээд санхүүжилтээс шалтгаалан барилгын ажил зогссон. | 70 |
| 10. | Төмөр замын салбарын стандартын хэрэгжилттэй танилцах тухай 2015.12.02 №326 | 2.Төмөр замын салбарын аан, байгууллагуудад стандартын үзлэг хийхэд холбогдох алба хэлтсээс төлөөлөгч оролцуулах ажлыг УБТЗ ХНН-ийн замын дарга /Л.Пүрэвбаатар/-д даалгасугай. | УБТЗ 2015.12.15 | Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 43 дугаар хавсралтаар баталсан төлөвлөгөөний 7-13 дугаарт заасан 6 стандартын төслийг боловсруулж ирүүлэх шаардлагатай. Стандартуудыг орчуулан боловсруулж байна. Боловсруулалтын явц 40%-тай байна. | 30 |
| | Үйл ажиллагаа хэрэгжүүлэх | 1. Болгар улсын Контракс ХХК-тай байгуулсан "Тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын нэгдсэн | АТҮТ | Болгар Улсын "Контракс" ХХК-тай байгуулсан "Тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын нэгдсэн | 0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 11. | тухай 2015.12.16 №346 | системийн тоног төхөөрөмжийн суурилуулалт, туршилт, тохируулгын ажил"-ын 45/А тоот гэрээгээр хүлээн авсан 6 дэд системийн баталгаат засварын хугацааг 6 сараар сунгахтай холбогдуулан дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг АТҮТ ТӨҮГ /Л.Пунцаг/-т даалгасугай. Үүнд 1.1. Хэрэглэгчийн шаардлагын дагуу 6 дэд систем дээр хийлгэх нэмэлт, өөрчлөлтийг тодорхойлж тухай бүр ирүүлэх | | системийн тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгын ажил"-ын 45/А тоот гэрээт ажлыг цуцалсан тухай мэдэгдлийг манай байгууллагад 2015 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 03/2152 тоот албан бичгээр ирүүлсэн. Түүнчлэн Зам тээврийн сайдын 2016 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 01/1471 тоот албан бичгээр "Wialon Local" тээврийн хэрэгслийн хяналтын програм, тоног төхөөрөмжийг ОХУ-ын "Веком" компанитай Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 63/37 тоот зөвлөмжийн 3.5.7 дахь заалтын дагуу шууд гэрээ байгуулан худалдан авах үүрэг өгсөн. Энэхүү үүргийн дагуу ОХУ-ын "Веком" компанитай 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр ЛГ16/001 дугаартай Лицензийн гэрээ байгуулан "Wialon Local" хяналтын програм худалдан авсан. Иймд Болгар Улсын нийлүүлсэн манай үйл ажиллагаанд тохиромжгүй, ашиглалтын зардал хэт өндөр, улсад болон байгууллагад хохиролтой, төсөвт дарамт учруулах дэд системүүд /програм/-д нэмэлт, өөрчлөлт хийлгэх шаардлагагүй болоод байна. 2015 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 03/2152 дугаартай албан бичгээр гүйцэтгэгчид гэрээ цуцлах тухай мэдэгдлийг, 2015 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 1/2292 тоот албан бичгийг Зам тээврийн яаманд тус тус хүргүүлсэн бөгөөд тодорхой шийдэлд хүрээгүй. Иймд уг тушаалыг хүчингүй болгуулах талаар ЗТХЯ-ны АТБХЗГ-тай ярилцаж байна. | |
| | | 1.2. Хэрэглэгчийн шаардлагын дагуу хийлгэж буй нэмэлт, өөрчлөлтийн талаар явцын мэдээллийг баталгаат засварын хугацаанд 14 хоног тутамд албан бичгээр ЗТЯ-д тайлагнаж байх. | АТҮТ | Зам, тээврийн яамнаас хүлээлгэн өгсөн дэд системүүд нь /програм/ манай үйл ажиллагаанд тохиромжгүй, ашиглалтын зардал хэт өндөр, улсад болон байгууллагад хохиролтой, төсөвт дарамт болох тул нэмэлт, өөрчлөлт хийлгэх шаардлагагүй. 2015 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 03/2152 дугаартай албан бичгээр гүйцэтгэгчид гэрээ цуцлах тухай мэдэгдэлийг, | 0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | 2015 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 1/2292 тоот албан бичгийг Зам тээврийн яаманд тус тус хүргүүлсэн бөгөөд тодорхой шийдэлд хүрээгүй. Иймд уг тушаалыг хүчингүй болгуулах талаар ЗТХЯ-ны АТБХЗГ-тай ярилцаж байна. | |
| | | 1.3. 2015 оны 12 сарын 15-ны өдрийн 04 дүгээр актаар хүлээн авсан Тээврийн хэрэгслийн бүртгэл мэдээллийн нэгдсэн систем, Авто үйлчилгээний байгууллагуудын нэгдсэн системүүд дээр хэрэглэгчийн шаардлагын дагуу хийлгэх нэмэлт өөрчлөлтийг яаралтай тодорхойлж баталгаат засварын хугацаанд багтаан хийлгэх | АТҮТ | Зам, тээврийн сайдын 2015 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 346 дугаар тушаалаар өгсөн үүрэг, мөн Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 03/5831, 2016 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 02/640 албан тоотоор тус Үндэсний төвд өгсөн үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын нэгдсэн системийн тоног төхөөрөмжийн угсралт суурилуулалт, туршилт, тохируулалтын ажлын хүрээнд хүлээлгэн өгч байгаа тээврийн хэрэгслийн бүртгэлийн нэгдсэн систем, Авто үйлчилгээний байгууллагуудын нэгдсэн системийг хүлээн авах ажлын хэсгийг тус төвийн Захирлын тушаалаар байгуулан ажиллаж байна. Автотээврийн үндэсний төвийн ажлын хэсэг нь Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 84 дүгээр тушаалаар байгуулагдсан "Ажлын хэсэг"-тэй систем хүлээлцэх асуудлаар 2016 оны 03 дугаар сарын 14-ний өдөр нэг удаа хуралдсан бөгөөд дахин хуралдаагүй байна.<br>Тээврийн хэрэгслийн бүртгэлийн системийг хүлээж авахтай холбогдуулан бүртгэлийн програмтай ажиллах сургалтыг Автотээврийн үндэсний төвийн Тээврийн хэрэгслийн бүртгэлийн газрын удирдах албан тушаалтнуудад хийсэн бөгөөд уг сургалт хийсэн өдөр тээврийн хэрэгслийн бүртгэлийн програм нь алдаа зааж ажиллахгүй байсан тул сургалт бүрэн гүйцэд хангалттай болж чадаагүй.<br>Тухайн сургалтын үеэр өмнөх системийн өгөгдлийн сан хөрвүүлэгдээгүй, хуучин тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн хийхэд тухай бүр нь өмнөх системээс нэг бүрчлэн таталт хийж байгаа нь тээврийн хэрэгслийн | 0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | статистик судалгаа гаргах боломжгүйд хүргэж байгааг тогтоосон. Иймд өмнөх системийн өгөгдлийн санг бүрэн хөрвүүлэх талаар болон шинэ системийг бүрэн ажиллагаатай болгох талаар Болгарын талд уламжилж шийдвэрлэхээр тогтсон боловч өнөөдрийг хүртэл автотээврийн хэрэгслийн бүртгэлийн системийг Автотээврийн үндэсний төвд хүлээлгэж өгөх талаар Зам, тээврийн хөгжлийн яамны зүгээс дорвитой ажил хийгдэхгүй байна. Одоогоор уг асуудал Авлигатай тэмцэх газар шалгагдаж байна. 2015 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 03/2152 дугаартай албан бичгээр гүйцэтгэгчид гэрээ цуцлах тухай мэдэгдэлийг, 2015 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 1/2292 тоот албан бичгийг Зам тээврийн яаманд тус тус хүргүүлсэн бөгөөд тодорхой шийдэлд хүрээгүй. Иймд уг тушаалыг хүчингүй болгуулах талаар ЗТХЯ-ны АТБХЗГ-тай ярилцаж байна. | |
| 12. | Авто замын чиглэл батлах тухай 2015.12.18 №357 | 2. Батлагдсан чиглэлийн дагуу авто замыг барих, ашиглах, шилжүүлэх гэрээ байгуулах, батлагдсан чиглэлийг мэдээлийн санд бүртгэж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг АЗТБХЗГ /Д.Доржханд/-т үүрэг болгосугай. /Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Баян-Ундарга нүүрсний уурхайгаас Хотгорын нүүрсний уурхай-Нарийнсухайт чиглэлийн авто замтай холбогдох 17.9 км авто замын чиглэл/ | АЗБХЗГ | Батлагдсан чиглэлийг мэдээллийн санд бүртгэж авсан. ГҮйцэтгэгч компаниас ирүүлсэн хүсэлтийн дагуу 2016.02.03-ны өдөр 01/16 дугаартай Инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын даалгавар баталж хүргүүлсэн. 2016.07.06-ны өдөр №05/09/2016 дугаартай ажил эхлүүлэх зөвшөөрөл авч зам барилгын ажлаа эхлүүлсэн. Замын далан, болон ухмалын ажил 100%, хиймэл байгууламжийн ажил 100%-ийн гүйцэтгэлтэй байна. Хөрөнгө оруулалтын асуудлаас шалтгаалан зам барилгын ажил зогссон. | 70 |
| | | 3. Авто замын нарийвчилсан зураг төслийг боловсруулж, зургийн дагуу шаардлага хангасан авто зам барьж, ашиглалтад оруулсны дараагаар тээвэрлэлтийг эхлүүлэхийг уурхай эзэмшигч компанид даалгасугай. | уурхай эзэмшигч компаниуд | 2016.07.06-ны өдөр №05/09/2016 дугаартай ажил эхлүүлэх зөвшөөрөл авсан, 2016 оны 7 сард зам барилгын ажлыг эхлүүлсэн. Замын далан, болон ухмалын ажил 100%, хиймэл байгууламжийн ажил 100%-ийн гүйцэтгэлтэй байна. Хөрөнгө оруулалтын асуудлаас шалтгаалан зам барилгын ажил зогссон. | 70 |
| 13. | Төмөр замаар дамжин өнгөрөх | 1.6. Сүхбаатар дахь ачаа, чингэлэг ачиж, буулгах цогцолборын техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөх, буулгах механизмыг шинэчлэх | УБТЗ | 2017 оны 05-р сарын 31-нд Сүхбаатар өртөөний МЧХ ачилтын 25, 26-р замуудад 100 ширхэг бетонон дэр солих засварын ажил хийсэн. | 30 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | тээврийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2015.12.22 №358 | | | 2017 оны 06-р сарын 11-нд МЧХ краны замын модон дэрийг бүрэн хэмжээгээр 223 ширхэг бетонон дэрээр солих засварын ажил хийж ул шороо өргөтгөлийн ажил хийсэн.<br>2017 оны 09-р сарын 12-с 09 сарын 20-ны дотор Ачиж буулгах хэсгийн талбайн гэрэлтүүлгийг шинэчлэх ажил хийгдэж байна. | |
| 14. | Ажлын хэсэг байгуулах тухай 2016.04.26 №103 | 4. Батлагдсан удирдамжийн дагуу хуулийн төслийг боловсруулж, үр дүнг ЗТЯ-ын зөвлөлд 2016 оны IY улиралд багтаан танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Ю.Өлзийжаргал/-д даалгасугай. /Хоолойн тээврийн тухай хуулийн төсөл боловсруулахад бусад орны туршлага судлах, мэргэжлийн холбоод, төрийн байгууллагуудтай хамтран ажиллах, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг/ нбд-Ч.Батбаяр | БТГ 2016.12.31 | Хоолойн тээврийн хөгжлөөр тэргүүлэгч орнуудын талаар судлан дараах орнуудын хуулийг орчуулан харьцуулан судалсан. Үүнд:<br>•Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнуудын Парламент хоорондын ассамблейн тогтоолоор батлагдсан “Дамжуулах хоолойн тээврийн загвар хууль”<br>•АНУ-ын “Дамжуулах хоолойг шинжлэн шалгах, хамгаалах, хуулийн хэрэгжилт хангуулах болон түүний аюулгүй ажиллагааны тухай хууль”<br>•ОХУ-ын “Үндсэн дамжуулах хоолойн тээврийн тухай хууль”<br>•Украйн Улсын “Хоолойн тээврийн тухай хууль”<br>•Беларусь Улсын “Үндсэн дамжуулах хоолойн тээврийн тухай хууль”<br>Хоолойн тээврийн тухай хууль боловсруулах талаар Зам, тээврийн сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэн “Хоолойн тээврийн тухай хууль”-ийн төсөл боловсруулахаар дэмжигдэн Ажлын хэсгийн хүрээнд зохих судалгаа хийж, Герман Улсад зохион байгуулсан “Олон улсын хоолойн тээврийн 11 дэх бага хурал”-д оролцон Монгол Улсад хоолойн тээврийг хөгжүүлэхэд техникийн туслалцаа үзүүлэх хүсэлтийг илэрхийлсэн. | 30 |
| 15. | Олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээн дэх замын байгууламжийн | 2. Халх гол сумын Сүмбэрийн боомт дахь Нөмрөгийн голын 320 у/м төмөр бетон гүүрийн барилгын Монголын талын гүүрийн ашиглалт, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, тэнхлэгийн даац, бүх жингийн | Дорнод зам ХК | Олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжийн урсгал засвар арчлалтын ажлын 2017 оны төлөвлөгөөгөөр Халх гол сумын Сүмбэрийн боомтод байрлах Нөмрөгийн голын 320 у/м төмөр бетон гүүрийн засвар арчлалтад хөрөнгө тусгагдаагүй тул | 0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хариуцагч томилох тухай 2016.07.05 №179 | хязгаарлалт хийж ажиллахыг "Дорнод зам" ХК-д үүрэг болгосугай. | | "Дорнод авто зам" ХК-д хариуцуулах боломжгүй байсан. Иймд 2018 оны засвар арчлалтын төлөвлөгөөнд уг гүүрэнд гүүр хамгаалагч-гэрээлэгчийн зардлыг тусгах төлөвлөгөөтэй байна. | |
| 16. | Ажлын хэсэг байгуулах тухай 2016.09.07 №19 | 2. Автотээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлагдсан үзэл баримтлалын дагуу шаардлагатай өөрчлөлтийг тусган боловсруулж, төсөлдөө төрийн захиргааны төв байгууллагын саналыг авч, 2016 онд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, улмаар УИХ-д өргөн барих ажлыг зохион байгуулахыг АТБХЗГ /С.Батболд/, ТЗУГ /Ж.Гантөмөр/, БТГ /Р.Мэргэн/ нарт тус тус үүрэг болгосугай. | АТБХЗГ ТЗУГ БТГ 2016.12.31 | Засгийн газар шинэчлэн байгуулагдсантай холбоотойгоор хуулийн төслүүдийг дахин боловсруулах чиглэлийг Засгийн газраас өгсөн. Автотээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд зөвлөх үйлчилгээ үзүүлэх Сивко Консалтинг ХХН-ийг сонгон шалгаруулж, “Автотээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулан Зөвлөх үйлчилгээний эцсийн тайланг 2017 оны 12 дугаар сард хүлээн авсан. Автотээврийн тухай хуулийн төслийг 2018.01.08-ны өдрийн Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэв. Сайдаас хуулийн төслийг дахин боловсруулах чиглэлийг өгсөн. Автотээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг хамтран батлахаар 2018.03.06-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайдад албан бичгээр хүргүүлээд байна. | 70 |
| 17. | Ажлын хэсэг байгуулах тухай 2016.10.06 №46 | 3. Тушаалын хэрэгжилтийг 2016 оны IY улиралд багтаан танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Цогтгэрэл/-д даалгасугай. /Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын зурвас газартай байршил нь давхцсан ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аан, байгууллага, иргэдийн өвөлжөө, үйлчилгээний зориулалт бүхий эзэмшлийн газрыг чөлөөлөх, нөхөн олговрын асуудлыг судлан санал боловсруулах, холбогдох эрх бүхий байгууллагуудад хандаж шийдвэрлүүлэх/ нбд-Т.Энхбаатар | Дэд сайд ТЗДТБХЗГ | трассын дагуу хууль зөрчиж олгогдсон газартай холбоотой асуудлаар Өмнөговь аймгийн Захиргааны хэргийн шүүхэд 2016 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 01/795, 12 дугаар сарын 20-ны 01/1182 дугаарын албан бичгээр “Монголын төмөр зам” ТӨХК-иас нэхэмжлэл гаргасан. Өмнөговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017.06.20-ны өдрийн 11 дугаар, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017.09.14-ны өдрийн 221/МА2017/0671 дугаар магадлалаар Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг даргын 2011.03.25-ны өдрийн 44 дүгээр захирамжийн Ш.Баттулга, О.Буджав нарт холбогдох хэсгийг хүчингүй болгож газар чөлөөлөхөөр шийдвэрлэсэн байна. Мөн шүүхийн | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | 2017.03.28-ны 07 дугаар шийдвэрээр Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын 2010.05.30-ны өдрийн А/52 дугаар захирамжийн иргэн Г.Ноовт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай" "МТЗ" ТӨХК-ийн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон байна. | |
| 18. | Салбар зөвлөл шинэчлэн байгуулах тухай 2016.10.21 №56<br><br>/2017.10.02-ны №201 тушаалаар өөрчлөлт оруулсан/ | 2. "Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдөж, салбар зөвлөлийн үйл ажиллагаар төлөвлөн зохион байгуулж, хэрэгжилт, үр дүнг Хэлний бодлогын үндэсний зөвлөлд танилцуулж ажиллахыг Салбар зөвлөл /Ж.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай. нбд-Д.Нарантуяа | ТНБД ТЗУГ | "Хэлний бодлогын орон тооны бус зөвлөл"-ийн 2017-2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл боловсруулан ажлын хэсгийн хурлыг 2017 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр хуралдуулсан.<br>Ажлын хэсгийн гишүүдээс "Хэлний бодлогын орон тооны бус зөвлөл"-ийн 2017-2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд ирүүлсэн саналыг тусган уг төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн дарга, "Хэлний бодлогын орон тооны бус зөвлөлийн даргаар батлуулав.<br>2017 оны 4 дүгээр улиралд Зам, тээврийн салбарын шинжлэх ухааны мэргэжлийн нэр томьёоны жагсаалтыг Монгол хэл, бичгийн тайлбартайгаар гаргах, Монгол хэл, бичгийн болон албан бичгийн хэм хэмжээг баримталж буй эсэхэд хяналт тавих нэгдсэн удирдамжийг гаргаж, харьяа байгууллагуудад хүргүүлж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | 30 |
| 19. | Ашиглалтын өмнөх удирдах хороо шинэчлэн байгуулах тухай 2016.11.17 №85<br><br>/2017.06.16-ны №123 тушаалаар | 2. УБ хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг ашиглалтад оруулах, бэлтгэл ажлыг бүрэн хангаж, нисэх буудлын ашиглалтын өмнөх үйл ажиллагааг нэгтгэн, удирдан зохион байгуулж, үйл ажиллагааны явц, төлөвлөгөөний хэрэгжилтийг ЗТХС, дэд сайдад тогтмол тайлагнаж ажиллахыг Ашиглалтын өмнөх удирдах хороонд даалгасугай. дарга-ТНБД, дэд дарга-ИНЕГ-ын Тэргүүн дэд дарга, нбд-ашиглалтын өмнөх захиргааны албаны дарга | ТНБД ИНЕГ | Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулах, үйл ажиллагаар эхлүүлэхэд тулгамдаж байгаа асуудлуудын талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат Засгийн газрын гишүүдэд 2017 оны 08 дугаар сарын 18-ны өдөр танилцуулж, 6 заалт бүхий Засгийн газрын 36 дугаар хуралдааны тэмдэглэл гарсан. | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | нэмэлт оруулсан/ | | | | |
| 20. | Зохицуулах хороо байгуулах тухай 2016.12.06 №109 | 2. Иргэний нисэхийн эрэн хайх, авран туслах үйл ажиллагааны бэлтгэл, төлөвлөлтийг зохицуулах хорооны үйл ажиллагаанд тус тусын чиг үүргийн дагуу мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг хорооны гишүүдэд үүрэг болгосугай. Дарга-ИНЕГ-ын дарга, нбд-ИНЕГ-ын тэргүүн дэд дарга | ИНЕГ | Иргэний нисэхийн эрэн хайх, авран туслах үйл ажиллагааны бэлтгэл, төлөвлөлтийг зохицуулах хорооны бүрэлдэхүүн, дүрмийг боловсруулж, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 109 дугаар тушаалаар батлууллаа. Зохицуулах хорооны дүрмийн 3 дугаар зүйлийн 3.5.8 дах хэсэгт заасан хорооны нарийн бичгийн даргын ажлын албаны бүрэлдэхүүнд ажиллах албан тушаалтны нэрсийг холбогдох 8 агентлагаас авсан. | 30 |
| | | 3. Иргэний нисэхийн эрэн хайх, авран туслах үйл ажиллагааны бэлтгэл, төлөвлөлтийг зохицуулах хороо, гишүүн байгууллагуудын уялдаа холбоог хангаж, хорооны үйл ажиллагааг дүрмийн дагуу зохион байгуулж ажиллахыг ИНЕГ /Л.Бямбасүрэн/-т даалгасугай. | ИНЕГ | Зохицуулах хорооны дүрмийн 3 дугаар зүйлийн 3.5.8 дах хэсэгт заасан хорооны нарийн бичгийн даргын ажлын албаны бүрэлдэхүүнд ажиллах албан тушаалтны нэрсийг холбогдох 8 агентлагаас авсан. | 30 |
| 21. | Удирдах болон хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай 2016.12.27 №129 | 2. Сангийн үйл ажиллагааг яамны бүтэц, зохион байгуулалтын нэгжийн чиг үүрэгтэй уялдуулан зохион байгуулж, журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн дарга нарт үүрэг болгосугай. Дарга-Р.Мэргэн, нбд-Ө.Одгэрэл, дарга-Т.Гомбосүрэн | ХШҮДАГ Байнгын | Хяналтын зөвлөл хуралдаагүй. | 0 |
| 22. | Бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах тухай 2017.03.24 №59 | 3. "Авто замын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг"-ийн төслийг 2017 оны III улиралд багтаан боловсруулж, дуусгах арга хэмжээ авахыг Ажлын хэсгийн дарга /Д.Доржханд/-д үүрэг болгосугай. Нбд-Б.Оюундэлгэр | АЗБХЗГ 2017.09.30 | Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам"-д бодлогын баримт бичиг боловсруулахдаа нөхцөл байдлыг шинжилгээ хийх, нөлөөллийн урьдчилсан үнэлгээг хийхээр заасан бөгөөд энэ хүрээнд бодлого боловсруулах суурь судалгааг хийх шаардлагатай болсон. Авто замын салбарт төрөөс баримтлах бодлогын баримт бичиг боловсруулах суурь судалгааны ажлыг зам, тээврийн салбарын норм нормативын сангийн хөрөнгөөр 2017-2018 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгаж батлуулсан. Бодлогын баримт | 30 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | бичгийн суурь судалгааны ажлын даалгаврыг боловсруулж, ТНБД-аар батлуулсан. Судалгааны ажлыг гүйцэтгэх зөвлөхөөр "Хязгааргүй хөдөлгөөн" ХХК-ийг 2017 оны 10 дугаар сард сонгон шалгаруулж гэрээ байгуулсан. Мөн бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсгийн хүрээнд бодлогын баримт бичгийг боловсруулахтай холбогдох баримт бичгүүдийг судлан, баримт бичгийн хамрах хүрээ, агуулгын төслийг боловсруулсан. Судалгааны ажлын үр дүнгээр бодлогын баримт бичгийн төслийн эцсийн хувилбарыг боловсруулна. | |
| 23. | Тээвэрлэлтийн чиглэл тогтоох тухай 2017.05.11 №94 | 2. Тогтоосон чиглэлд тээвэрлэлт гүйцэтгэх аан-тэй улс хоорондын байнгын ачаа тээврийн гэрээ байгуулан хэрэгжилтийг хангуулж ажиллахыг АТҮТ ТӨҮГ /П.Дэлгэрнаран/-т, өөрийн эзэмшлийн 17.9 км авто замын засвар, арчлалтыг бүрэн хариуцаж, 2017 онд багтаан хучилтыг хийж дуусгахыг "Жавхлант орд" ХХК-д тус тус олгосугай. /Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Баян-Ундаргын нүүрсний уурхайгаас Шивээхүрэн-Сэхээ боомт хүртэлх улс хоорондын ачаа тээвэрлэлтийг "Жавхлант орд" ХХК-ийн авто зам-"Ноби Коул энд Энержи" ХХК-ийн авто зам-"Терра Энержи" ХХК-ийн авто зам-"Ар Ди Си Си" ХХК-ийн хүнд даацын хатуу хучилттай авто замаар гүйцэтгүүлэх/ | уурхай эзэмшигч компани | Хучилтын ажил хийгээгүй. | 0 |
| | | 3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг АЗБХЗГ /Д.Доржханд/, АТБХЗГ /С.Батболд/, ХШҮДАГ /Т.Гомбосүрэн/-т тус тус даалгасугай. | АЗБХЗГ АТБХЗГ ХШҮДАГ | Сайдаас 01/5482 дугаар албан бичгээр "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-аас тээвэрлэгч аж ахуйн нэгжтэй тээвэрлэлтийн гэрээ байгуулахгүй байх чиглэл өгсөн. "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ тээвэрлэгч аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулахгүй болсон тул "Жавхлант орд" ХХК нь "Жун-Юу" ХХК-тай тээвэрлэлтийн гэрээ байгуулан 2017 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар 11200 тонн нүүрс тээвэрлэн экспортолсон. "Жавхлант Орд" ХХК авто замын суурийн ажлыг хийсэн, авто замын хучилтын ажлыг 2018 оны эхний хагаст хийхээр ажиллаж байна. | 30 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 24. | Орон тооны бус салбар зөвлөл байгуулах тухай 2017.05.22 №108<br><br>2018.02.28-ны №34 тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан/ | 2. Орон тооны бус салбар зөвлөлийн дүрэм, "Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлуулахыг Салбар зөвлөл /Ж.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай. /"Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий ЗТХЯ-ны дэргэдэх орон тооны бус салбар зөвлөл/ нбд-Д.Оюунсүрэн | ТНБД ТЗУГ | “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх орон тооны бус салбар зөвлөлийг төлөөлж, ТЗУГ-ын Хуулийн хэлтсийн дарга Н.Бат-Эрдэнэ 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн Шадар сайдаас зарласан “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үйл ажиллагааны талаарх бусад яамдын 2017 оны тайлан”-г хэлэлцүүлэх хуралдаанд оролцож санал, хүсэлтээ илэрхийлж оролцов.<br>2018 оны төлөвлөгөө боловсруулж, батлуулахаар ажиллаж байна. | 70 |
| 25. | Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай 2017.06.07 №115 | 2. Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулж, Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлэхээр хүргүүлэх ажлыг 2017 оны 10 дугаар сард багтаан зохион байгуулахыг Ажлын хэсгийн ахлагч /Ч.Мэргэн/, ТЗУГ-ын дарга /Ж.Гантөмөр/ нарт даалгасугай. дэд ахлагч-Б.Артур, нбд-Т.Мөнхцэцэг | БТГ ТЗУГ ТЗДТБХЗГ 2017.10.30 | Ажлын хэсгийн төлөвлөгөөг батлан эхний хуралдааныг 2017.06.19-нд хийж, гишүүдэд удирдамж чиг үүргийг танилцуулж, төлөвлөгөөний дагуу хугацаатай чиглэл өгсөн. Хууль тогтоомжийн тухай хуульд заасан аргачлалын дагуу судалгаа, дүгнэлт гаргаж байна. 2017 оны 3 дугаар улиралд Ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон санхүүжилтийг батлуулж, шийдвэрлэсэн.<br>Хуулийн хэрэгжилтэд үнэлгээ өгөх дэд ажлын хэсэг дүгнэлт гаргаад байна. Мөн хуулийн хэлэлцүүлгийг “ГТХЗНТ” УТҮГ, “УБТЗ” ХНН, “МТЗ” ТӨХК-ууд дээр хийсэн. Хэлэлцүүлгээс гарсан санал, хүсэлтүүдийг хуулийн үзэл баримтлал болон хуулийн төсөлдөө тусгахаар ажиллаж байна.<br>Ажлын хэсэг Сүхбаатар болон Замын-Үүд чиглэлийн зангилаа өртөөнүүд дээр ажиллаж, 2007 оны төмөр замын тээврийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээ, дүгнэлтийг танилцуулж санал солилцоод байна.<br>Ажлын хэсэг 2018 оны 02 дугаар сарын 26-ны 08/806 дугаар албан бичгээр харьяа байгууллагаас хуулийн үзэл баримтлалын төсөлд санал авч 03 дугаар сарын 23-ны өдөр салбарын хүрээнд хэлэлцүүлэг хийсэн. | 30 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 26. | Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамж батлах тухай 2017.06.09 №119 | 2. "Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх" төслийн 2 дугаар шатыг үр дүнтэй зохион байгуулахыг Ажлын хэсгийн ахлагч /С.Батболд/-д үүрэг болгосугай. Нбд-Э.Мөнхнасан | АТБХЗГ БТГ | БНСУ-ын Экзим банкны хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжиж байгаа Улс, хот хоорондын нийтийн тээврийг дэмжих төслийн 2 дугаар шатанд зөвлөх үйлчилгээ авч нийтийн тээврийн чадавхийг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулах талаар тусган ажлын даалгаврыг ТНБД-аар батлуулж, 2017 оны 05 дугаар сард Сангийн яам болон БНСУ-ын Экзим банкинд хүргүүлсэн боловч БНСУ-ын Экзим банктай ажлын даалгаврын цар хүрээнд дээр тохироогүй болно.<br>Мөн энэхүү төслийн 2 дугаар шатанд нийлүүлэгдэх автобусыг хотын нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглах санал гарган Сайдын зөвлөлийн 2018.01.08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох саналыг Сангийн яам, БНСУ-ын Экзим банкинд хүргүүлсэн боловч төслийн зориулалтыг өөрчлөх боломжгүй гэсэн хариуг ирүүлээд байна.<br>Төслийн хэрэгжих хугацаа дуусч байгаатай холбоотойгоор тус төслийг цаашид хэрэгжих боломжгүй гэж үзэж, тусгайлсан зээлийн хэлэлцээрийг хугацаанд нь дуусгаж, БНСУ-ын Экзим банктай нэмэлтээр байгуулсан 500 сая ам.долларын Ерөнхий зээлийн хэлэлцээрийн хүрээнд нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төслийг хэрэгжүүлэхээр Сангийн яамнаас санал гаргаад байна. | 30 |
| 27. | Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2017.06.27 №132 | 2. УИХ, ЗГ-ын тогтоолоор баталсан үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг салбарын бодлого, зорилт яамны үйл ажиллагаатай уялдуулан төлөвлөн зохион байгуулж, хөтөлбөрүүдийг хэрэгжилт, үр дүнг Сайдын зөвлөлд хагас жил тутам танилцуулж ажиллахыг ажлын хэсэг /Ж.Бат-Эрдэнэ/-д даалгасугай. нбд-Д.Цэцэгмаа | ТНБД ТЗУГ | Уг асуудлыг БТГ-ын мэргэжилтэн Б.Өлзийжаргал хариуцан ажиллаж байгаа бөгөөд өмнөх тушаалд заасан хэвээр нарийн бичгийн даргыг томилсон байгааг залруулж, тушаалд өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа болно. Энэ тухай Б.Өлзийжаргалд мэдэгдсэн болно. | |
| 28. | Хэлэлцээрт оролцох бүрэлдэхүүнийг томилох тухай | 2. Монголын авто замчдын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо, Монголын Авто замчдын холбоотой авто замын салбарын 2017-2019 оны гурван талт хэлэлцээрийг хийж танилцуулахыг хэлэлцээр хийх бүрэлдэхүүний ахлагч, дэд сайд | Джд сайд АЗБХЗГ | 2017 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр Зам,тээврийн хөгжлийн яамны бүрэлдэхүүн, Монголын авто замчдын холбоо, Монголын авто замчдын Үйлдвэрчний эвлэлийн холбооны бүрэлдэхүүнтэй хамтарсан хэлэлцүүлгийг хийж, бүрэлдэхүүн тус бүрээс гурван | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 2017.08.02 №149 | /Б.Цогтгэрэл/-д үүрэг болгосугай. Дэд ахлагч-Д.Доржханд, нбд-С.Баярчимэг | | гишүүн оролцон 2018-2019 оны хамтын хэлэлцээрийн төсөлд редакц хийсэн.<br>Тал бүрээс 3 хүний төлөөлөл дахин уулзаж, хэлэлцээрийн төслийг дахин хэлэлцэхээр шийдвэрлэсэн. | |
| 29. | Эрх шилжүүлэх тухай 2017.08.17 №164 | 3. Эрх шилжүүлсэнтэй холбогдуулан тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор хөндлөнгийн хяналт тавих, гүйцэтгэлийг хянах, баталгаажуулах, санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг ТНБД Ж.Бат-Эрдэнэд даалгасугай. /Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төслийн хүрээнд 2017 онд хэрэгжүүлэх 2 ажил/ | ТНБД БТГ АЗБХЗГ | Тушаалын хавсралтад заасан "100 айлын уулзварын барилгын ажил"-ын санхүүжилтийг Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц төслийн нэгжээс хянан баталгаажуулж ирүүлсний дагуу АЗБХЗГ, ТЗУГ-тай хамтран хянаж, Сангийн яаманд хүргүүлэх санхүүжилтийн хүсэлтийг ТНБД-д танилцуулсан.<br>"Сонгинохайрхан дүүрэг, Үйлдвэрчний эвлэлийн гудамжийг Москва хорооллын арын далангаар явуулж, Өнөр хорооллын 33 дугаар байрны арын замтай холбох 1 км авто замын зам барилгын ажил"-ыг хэрэгжүүлэх эрхийг НЗД-д шилжүүлсэн боловч НЗД-ын Тамгын газрын Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Өлзийбаярын 2017 оны 10 дугаарс арын 03-ны өдрийн 05/3349 тоот албан бичгээр уг ажлыг 2017 оны төсвийн жилд багтаан хэрэгжүүлэх боломжгүй байна гэсэн хариуг ирүүлсэн. | 30 |
| 30. | Төсөл, арга хэмжээний жагсаалт батлах тухай 2017.09.12 №180 | 2. Батласан төсөл, арга хэмжээг ТБОНӨХБАҮХАтХ-ийн дагуу зохион байгуулж, төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэхийг ТНБД /Ж.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай. /"Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын төслийн Өлгий-Ховд чиглэлийн авто замын үргэлжлэл хатуу хучилттай 189.7 км авто зам" барих төслийн хүрээнд Монголын талын хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт"-5/ | ТНБД БТГ АЗБХЗГ | Хавсралтад дурдагдсан "Авто замын засвар арчлалтын тоног төхөөрөмж, машин механизм худалдан авах, Багц-1" ажлын тендерийг шалгаруулж, "Бадрангуй орших" ХХК-тай гэрээ байгуулсан. 2018 оны Улсын төсөвт тусгагдсан хөрөнгөөр нийт 10 ш машин механизмыг нийлүүлж, машин механизм дутагдалтай байгаа Завхан АЗЗА ТӨХК, Талын зам ТӨХК, Архангай АЗЗА ТӨХК, Өвөрхангай АЗЗА ТӨХК, Ховд АЗЗА ТӨХК-иудад хуваарилан 2018.03.15-нд хүлээлгэн өгсөн. | 30 |
| 31. | Төсөл, арга хэмжээний жагсаалт батлах тухай 2017.09.21 №191 | 2. Жагсаалтын 3. 4. 5 болон 17-д заасан УБ хотод "Олон улсын шинэ нисэх буудал барих төслийн хүрээнд Монголын талын 2017 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ", "УБ хотод ОУ-ын шинэ нисэх буудал барих төслийн навигацийн үйлчилгээний бэлтгэл ажлыг хангах тоног төхөөрөмж", "ОУ-ын шинэ нисэх буудлын навигацийн тоног төхөөрөмж | ИНЕГ | ЗТХС-ын 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 44 дугаар тушаалаар "Олон улсын шинэ нисэх буудал барих төслийн хүрээнд Монголын талын 2018 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ", "Улаанбаатар хотод Олон улсын шинэ нисэх буудал барих төслийн ашиглалтын өмнөх бэлтгэл ажлыг хангах тоног төхөөрөмж", "Олон улсын шинэ нисэх буудлын | 30 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | болон шинээр зохиогдох нислэгийн журмыг шалгалтын нислэгээр шалган баталгаажуулалт, гэрчилгээжүүлэлт", "Ландшарфт /барилга, байгууламжийн гадна зүлэгжүүлэлт, тохижилт/"-ын ажлыг холбогдох хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулж, бүрэн хэрэгжүүлэхийг ИНЕГ /Л.Бямбасүрэн/-т үүрэг болгосугай. | | навигацийн тоног төхөөрөмж болон шинээр зохиогдох нислэгийн журмыг шалгалтын нислэгээр шалган баталгаажуулалт, гэрчилгээжүүлэлт", "Ландшафт /барилга, байгууламжийн гадна зүлэгжүүлэлт, тохижилт" -ийн ажлын тендер шалгаруулалтыг хуулийн дагуу зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар ажиллаж байна. Олон улсын нисэх онгоцны шинэ буудлаас дулааны станц хүртэлх 2.9 км хатуу хучилттай авто зам, замын хяналтын зөвлөх үйлчилгээ, замын зураг төсөл боловсруулах ажлыг 2017 онд нээлттэй тендер зарлаж 2017.12.18-нд ажил гүйцэтгэх гэрээ батлагдсан ба ажлыг эхлүүлсэн байна. Бусад төсөл, арга хэмжээнүүдийн нээлттэй тендер зарлахаар төлөвлөж байна. | |
| 32. | Ажлын хэсэг байгуулах тухай 2017.11.07 №223 | 2. "Автотээврийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг"-ийн төслийг 2017 оны 4 дүгээр улиралд багтаан боловсруулж, дуусгах арга хэмжээ авахыг Ажлын хэсгийн дарга /С.Батболд/-д үүрэг болгосугай. Нбд-Э:Мөнхнасан | АТБХЗГ БТГ 2017.12.30 | "Автотээврийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг"-ийн төсөл болон холбогдох судалгаа, шинжилгээг хийж Сайдын зөвлөлийн хурлаар 2018.01.09-ны өдрийн хуралд танилцуулсан. Хуулийн төсөлтэй уялдуулж дахин боловсруулж танилцуулах чиглэл өгөгдсөн тул Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасны дагуу холбогдох тандан судалгаа, нөлөөллийн шинжилгээг хийж байна. Нийт 4 хэлэлцүүлэг хийхээр төлөвлөснөөс 1 удаагийн хэлэлцүүлгийг Автотээврийн удирдах ажилтны зөвлөгөөний үеэр хэлэлцүүлээд байна. | 70 |
| 33. | Дотоодын ачаа тээвэрлэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2017.11.15 №229 | 1. Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн эрэлт хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам тээврийн ложистикийн сүлжээг хөгжүүлэх зорилгоор дараах арга хэмжээ авч ажиллахыг АТҮТ ТӨҮГ /П.Дэлгэрнаран/, Нийслэлийн тээврийн газар /Д.Отгонбаатар/-т тус тус даалгасугай. 1.1. Хүнсний түргэн гэмтэх, эмзэг бүтээгдэхүүний чанар байдлыг алдагдуулахгүйгээр стандартын шаардлага хангасан зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэж буй байдалд тавих хяналт | АТҮТ Нийслэлийн тээврийн газар | Хүнсний тээвэрлэлтийг зориулалтын тээврийн хэрэгслээр гүйцэтгүүлэх арга хэмжээний талаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран ажиллахаар төлөвлөж байна. | 0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | шалгалтыг сайжруулах чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах | | | |
| | | 1.3. УБ хотын хэмжээнд дотоодын ачаа тээврийн нэгдсэн түгээлтийн системийг бий болгох, зохион байгуулалтад оруулах, интернет худалдаа буюу цахим хэлбэрээр ачаа, барааг захиалах, хүлээн авах, бүртгэлжүүлэх, гараас гарт хүргэх тээвэрлэлтийн үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр холбогдох аан, байгууллагуудтай хамтран ажиллах | АТҮТ Нийслэлийн тээврийн газар | Уг тушаалыг хэрэгжүүлэх Ажлын хэсэг 2018.03.13-ны өдөр хуралдаж санал солилцон, ажлын төлөвлөгөө боловсруулахаар болсон. Үүний дагуу ажлын хэсгийн гишүүдээс төлөвлөгөөнд тусгах санал авч байна. | 30 |
| 34. | Ажлын хэсэг байгуулах тухай 2017.11.23 №235 | 4. Ажлын хэсгийн хэрэгжүүлж буй үйл ажиллагааны явц, үр дүнгийн талаар яамны удирдлагад тухай бүр танилцуулж, чиглэл авч ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч /ЗТХ-ийн дэд сайд/-д даалгасугай. /Төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээврийг нэмэгдүүлэх зорилгоор ОХУ болон БНХАУ-ын талтай хэлэлцээ хийх, хилийн хяналт шалгалтыг хөнгөвчлөх талаар санал боловсруулах/ нбд-ТЗДТБХЗГ-ын тээвэр зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн | Дэд сайд ТЗДТБХЗГ | БНПУ-ын Варшав хотноо 2018 оны 02 дугаар сарын 26-аас 03 дугаар сарын 02-ны хооронд зохион байгуулагдсан "Төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын төмөр замуудаар 2018 онд тээвэрлэх гадаад худалдааны ачааны хэмжээ тохиролцох хурал"-д "УБТЗ" ХНН-ийн дарга Д.Жигжиднямаагаар ахлуулсан төлөөлөгчид оролцож, 2018 онд Монгол Улсын нутгаар 3.41 сая тонн дамжин өнгөрөх ачаа тээвэрлэхээр тохиролцсон нь өмнөх оны нийт гүйцэтгэлээс 12 хувиар илүү ачаа тээвэрлэхээр болсон. Мөн дамжин өнгөрөх тээврийн хэмжээг нэмэгдүүлэх, төмөр замын төв коридорыг олон улсад сурталчлах зорилгоор 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр ОХУ-ны Москва хотноо "Транзит Монгол-2018" арга хэмжээг зохион байгуулахаар шийдвэрлэж, ЗТХ-ийн дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг бэлтгэл ажлыг хангаж байна. Хилийн хяналт, шалгалтыг хөнгөвчлөх зорилгоор санал боловсруулан Монгол-Оросын ЗГХК-ийн хуралдаанаар хэлэлцүүлэх хүсэлтийг Гаалийн Ерөнхий газарт хүргүүлсэн. | 70 |
| 35. | Ажлын хэсэг байгуулах тухай 2017.11.23 №237 | 4. Ажлын хэсгийн хэрэгжүүлж буй үйл ажиллагааны явц, үр дүнгийн талаар яамны удирдлагад тухай бүр танилцуулж, чиглэл авч ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч /ЗТХ-ийн дэд сайд/-д даалгасугай. /"Оросын төмөр замууд" НХН-тэй хэлэлцээ хийх, түүнчлэн хамтран гуравдагч талуудтай хэлэлцээ хийх үүрэг бүхий/ нбд-ТЗДТБХЗГ-ын хөдлөх | Дэд сайд ТЗДТБХЗГ УБТЗ | Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 237 тоот тушаалаар байгуулагдсан "Улаанбаатар төмөр замын шинэчлэл, хөгжлийн стратегийн түншлэлийн тухай хэлэлцээр"-т туссан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор "Оросын төмөр замууд" НХН болон гуравдагч талуудтай хэлэлцээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийн анхны хурлыг 2018 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр зохион | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | бүрэлдэхүүн хариуцсан мэргэжилтэн, УБТЗ-ын Замын ерөнхий инженерийн орлогч дарга | | байгуулсан. Ажлын хэсэг шинэчлэгдсэнтэй холбогдуулан 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 08/25 тоот албан бичгээр "Оросын төмөр замууд" НХН-т мэдэгдсэн. Хэлэлцээрт туссан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зорилгоор ажлын хэсгийн төлөвлөгөөг боловсруулж байна. Мөн ажлын хэсгийн удирдамжид туссан "Транзит Монгол-2018" арга хэмжээг 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр ОХУ-д зохион байгуулахаар бэлтгэл хангаж ажиллаж байна. | |
| 36. | Ажлын хэсэг байгуулах тухай 2017.11.23 №238 | 3. Ажлын хэсгийн үйл ажиллагааг зохион байгуулж, санал дүгнэлтийг ЗТХ-ийн сайдад 2017.12.22-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д даалгасугай. /Агаарын тээврийн үнэ тарифын зохицуулалтын талаар судалгаа хийж, санал дүгнэлт боловсруулах/ нбд-Ө.Мөнгөнжигүүр | ТНБД АТБХЗХ 2017.12.22 | Онгоцны билетний үнэ бууруулах, зорчигчийн тийз борлуулагч агентуудын үйл ажиллагааг шалгах үүрэг бүхий ажлын хэсгийг ЗТХ-ийн сайдын 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 238 дугаар тушаалаар байгуулав. Ажлын хэсэг 2017 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр хуралдаж, “УБ-Пусан” чиглэлийн нислэгийн тийзний үнийг бууруулах талаар судлахаар тогтов. “МИАТ” ТӨХК-ийн нислэгийн тарифыг зорчигчдын 70%-д 30 ам.доллараар бууруулах тооцооллыг хийж үзэхэд тус компанийн алдагдал энэ 2018 оны эхний 5 сард 1,4-1,8 тэрбум төгрөг/ нислэг гүйцэтгэх агаарын хөлгийн маягаас хамааран/ болж өсөхөөр байгаа бөгөөд тус компани уг асуудлыг ТУЗ-даа тавьж шийдвэрлүүлэхээр хариу ирүүлээд байна.<br>“Эйр Бусан” компани 2018.01.04-с эхлэн УБ-Бусан-УБ чиглэлийн нислэгийн 2 талын тийзний үнийг 30.0 ам.доллараар бууруулаад байна. | 70 |
| 37. | Нууцын ажлыг сайжруулах зарим арга хэмжээний тухай 2017.12.04 №252 | 1.5. Төрийн нууцтай танилцах албан тушаалтны жагсаалт гарган батлах | ТЗУГ харьяа агентлаг, байгууллага | Зам, тээврийн хөгжлийн яамны төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг гарган Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-т заасны дагуу санал авахаар 2018 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Төрийн нарийн бичгийн даргын 03/1310 тоот албан бичгээр хүргүүлээд байна.<br>АТҮТ, МТЗ батлуулсан. Бусад байгууллагууд батлуулаагүй байна. | 30 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 38. | Тогтоол хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2017.12.15 №260 | 1. "УБ хотын ОУ-ын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл"-ийг хэрэгжүүлэх Монгол-Японы хамтарсан хуулийн этгээд байгуулах ажлыг зохион байгуулахыг ЗТХЯ-ны БТГ /Р.Мэргэн/, АТБХЗХ /С.Мөнхнасан/-т үүрэг болгосугай. | БТГ<br>АТБХЗХ | Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл"-ийг хэрэгжүүлэх Монгол-Японы хамтарсан хуулийн этгээд байгуулах ажлын бэлтгэл ажлын хүрээд японы талын 4 түншлэгч компани, "Чингис хаан" олон улсын нисэх буудал хооронд "Түншлэлийн гэрээ"-г 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр байуулаад байна. Түншлэлийн гэрээний хуулбар болон холбогдох материалыг Сангийн яам, Гадаад харилцааны яам, Үндэсний хөгжлийн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тус тус мэдээлэл өгөхөөр 2018 оны 02 дугаар 07-ны өдөр хүргүүлсэн. Монголын талын хувь эзэмшигч этгээд, хамтарсан хуулийн этгээдийн төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээдийг тогтоох талаар Засгийн газрын тогтоолын төсөл бэлтгэх шатанд байна. | 30 |
| 39. | Төлөвлөгөө батлах тухай 2017.12:28 №269 | 2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг ТБОНӨХБАҮХАтХ-ийн дагуу хэрэгжилтийг зохион байгуулахыг ТНБД /Ж.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай. /ЗТХ-ийн сайдын багцын 2018 онд бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө/ 35 арга хэмжээ | ТНБД<br>БТГ | Зам, тээврийн хөгжлийн сайдын багцын 2018 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд нийт 35 төсөл, арга хэмжээ туссанаас 15 төсөл, арга хэмжээг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018.01.22-ны өдрийн 09 дүгээр тушаалаар аймаг, орон нутагт эрх шилжүүлсэн. Үлдсэн 20 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд зохион байгуулан ажиллаж байна. | 30 |
| 40. | Эрх шилжүүлэх тухай 2018.01.22 №09 | 2. Энэхүү тушаалын хавсралтаар баталсан төсөл, арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг хянах, баталгаажуулах, холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавих ажлыг шуурхай зохион байгуулахыг эрх шилжүүлэн авсан албан тушаалтанд үүрэг болгосугай. /МУ-ын төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн ЗТХС /ТЕЗ/-ын багцаас Нийслэлийн Засаг даргад 7, Архангай аймгийн ЗД- | Нийслэл<br>Архангай<br>Завхан<br>Баян-Өлгий<br>Увс<br>Төв | биелэлт ирүүлээгүй | 0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | д 1, Завханы ЗД-д-1, Баян-Өлгийн ЗД-д-1, Увсын ЗД-д-4, Төв аймгийн ЗД-д-1/ | | | |
| | | 3. Эрх шилжүүлсэнтэй холбогдуулан тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор хөндлөнгийн хяналт тавих, гүйцэтгэлийг хянах, баталгаажуулах, санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг ТНБД Ж.Бат-Эрдэнэд даалгасугай. /авто зам-13, нисэх-1, авто тээвэр-1/ | ТНБД БТГ | Тушаалын хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор аймаг, орон нутгийн засаг дарга нарт 2018.03.09-ний өдрийн 03/991 тоот албан бичгээр тушаалын хэрэгжилтийг хангаж, сар бүрийн эхний долоо хоногт худалдан авах ажиллагааны тайлан мэдээг ирүүлж байхыг мэдэгдсэн. | 30 |
| 41. | Ажлын хэсэг байгуулах тухай 2018.01.24 №14 | 3. Батлагдсан удирдамжийн дагуу Ажлын хэсгийг зохион байгуулан шаардлагатай тохиолдолд дэд ажлын хэсэг байгуулан ажиллуулж, бодлогын баримт бичгийн төслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу эцэслэн боловсруулж, 2018 оны 2 дугаар сард багтаан ЗТХС-ын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Ажлын хэсэг /Б.Цогтгэрэл/-т даалгасугай. нбд-Ч.Мөнхтуяа, Г.Батбаяр | Дэд сайд БТГ ИНЕГ 2018.02.28 | “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын 2 заалтад өөрчлөлт оруулах төсөл, УИХ-ын тогтоолын төсөл, үзэл баримтлал, холбогдох баримт бичгийн бүрдлийг бэлтгэсэн, яамны удирдлагад танилцуулах шатанд байна. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн дагуу Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын холбогдох заалтын хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэхээр ажиллаж байна. | 70 |
| | | 4. "Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого"-д нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой асуудлыг 2018.03.21-ний өдрийн дотор ЗГХ-д танилцуулах арга хэмжээ авахыг Ажлын хэсэг /Б.Цогтгэрэл/ болон БТГ /Р.Мэргэн/, ТЗУГ /Б.Махбал/-т тус тус даалгасугай. | Дэд сайд БТГ ТЗУГ 2018.03.21 | “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын 2 заалтад өөрчлөлт оруулах төсөл, УИХ-ын тогтоолын төсөл, үзэл баримтлал, холбогдох баримт бичгийн бүрдлийг бэлтгэсэн, яамны удирдлагад танилцуулах шатанд байна. | 30 |
| 42. | Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих тухай 2018.02.08 №23 | 1. Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих зорилгоор зам, тээврийн салбарт худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль, тогтоомжийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллахыг яамны газар болон харьяа байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.<br>1.1. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт”-д заасан барааг нийлүүлэх шалгуур шаардлагыг тендерийн баримт бичигт тодорхой зааж, дотоодын үйлдвэрлэгчийн бараа бүтээгдэхүүнийг худалдаж авах чиглэлийг баримтлах; | БТГ харьяа агентлаг, байгууллага | Уг тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн яамны 2018 оны 04/681 тоот албан бичгээр харьяа байгууллагуудад хүргүүлсэн. Зам, тээврийн хөгжлийн яаманд хэрэгжих бараа, ажил, үйлчилгээний зарим худалдан авалтын тендерийн баримт бичигт дотоодын үйлдвэрлэлийг дэмжин ажиллах талаар тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 30 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 1.2. Зам, тээврийн салбарт бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дотоодын үйлдвэрлэгчийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн сонгохыг дэмжих, дотоодын давуу эрх тооцох нөхцлийг тендерийн баримт бичигт тусгаж ажиллах; | БТГ харьяа агентлаг, байгууллага | | 0 |
| | | 1.3. Дотоодын аж ахуй нэгжүүдийн ирүүлсэн тендерийн үнийг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт заасны дагуу хийсвэрээр бууруулж тооцох; | БТГ харьяа агентлаг, байгууллага | | 0 |
| | | 1.4. Тендерт оролцогчдод давуу эрх олгохдоо Сангийн сайдын 2007 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 81 дүгээр тушаалаар батлагдсан "Тендерт оролцогчдод давуу эрх олгох аргачлал"-ыг мөрдлөг болгон ажиллах. | БТГ харьяа агентлаг, байгууллага | | 0 |
| | | 2. Тендерт оролцогчдод давуу эрх олгосон талаархи мэдээг худалдан авах ажиллагааны улирлын тайланд дэлгэрэнгүй тусган тайлагнахыг харьяа байгууллагуудын дарга нарт даалгасугай. | харьяа агентлаг, байгууллага | | 0 |